

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

**Улаанбаатар
2022 он**

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Энэхүү үнэлгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

Ингэхдээ хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгасан зорилгод хүрэхэд чиглэгдсэн, тус зорилгод хүрэх боломжтой эсэх болон хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагыг хангах боломжтой эсэх талаар голчлон анхаарч, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний тайлан нь хуулийн төслийг бүхэлд нь хамрахгүй бөгөөд гагцхүү тайланд тусгасан үнэлгээ хийсэн шалгуур үзүүлэлт болон хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгээр хязгаарлагдах юм.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

Үнэлгээ хийх үе шат:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Нэг.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын 1.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны эхний үе шат нь шалгуур үзүүлэлтийг сонгох үе шат юм. Аргачлалын 2.2-т хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх зургаан төрлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг тогтоосон нь “зорилгод хүрэх байдал”, “практикт хэрэгжих боломж”, “ойлгомжтой байдал”, “хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “зардал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтүүд байна.

Аргачлалын 2.9-т шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тооцож болох тухай заасан байна. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ

/цаашид “Үнэлгээ” гэх/-г “зорилгод хүрэх байдал” болон “харилцан уялдаа” гэсэн хоёр үндсэн шалгуур үзүүлэлтийг сонгож үнэлгээг хийв.

1.1.“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлав. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглав.

1.2.”Харилцан уялдаа”- гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгав.

Хоёр.

Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон байдал

Аргачлалын 1.4.2-т заасан ёсоор үнэлгээний хоёр дахь үе шат нь хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгийг сонгох үе шат байна. Энэхүү үе шатанд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсэг буюу тодорхой зохицуулалтуудыг сонгон авах тул үнэлгээг бодитой хийх үүднээс хуулийн төслийн чухал ач холбогдолтой, гол хэсгийг сонгож авав.

Энэ талаар Аргачлалын 3.2-т “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй” хэмээн заасан байна. Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан, хуулийн төслийн гол, чухал ач холбогдолтой зохицуулалт агуулсан зүйл, заалтуудыг сонгон авч үнэлгээ хийхийг чухалчлав.

2.1.”Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс дараах 2 хэсгийг сонгов:

1/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн Үзэл баримтлалд Тамхи, тамхин бүтээгдэхүүний нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой болгож, хуульд тусгагдаагүй байсан шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний төхөөрөмжийн тодорхойлолтыг тусгаж, хуулийн зохицуулалтад оруулах” гэсэн байна. Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн энэ талаарх зохицуулалтууд болох 2.1, 3.1,1, 3.1.1.1, 3.1.1.2, 3.1.1.3, 3.1.1.4, 3.1.1.5, 9 дүгээр зүйл, 9.1 дахь заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

2/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн Үзэл баримтлалд “Дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа байгууллагын орох хаалганы гадна талаас 10-15 метрт зайд тамхи татах цэгийг байгуулж тамхины утаанд өртөлтийг багасгана.” гэсэн байна. Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн энэ талаарх зохицуулалтууд болох 2.1, 3.1.11, 5.1.6, 5.1.7, 5.2.4, 5.2.5, 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

Хуулийн төслийн дээрх хоёр хэсгийн үр нөлөөг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх болно. Ингэснээр хуулийн төслийн холбогдох заалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилгод хүрч чадахуйц эсэхийг үнэлэх юм.

2.2.”Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

Гурав.

Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлнэ. Шалгуур үзүүлэлтэд тохирох дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

№	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

3.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

“Зорилгод дүн шинжилгээ хийх” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ тухайн хуулийн төсөлд тавьсан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн эсэх, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх бөгөөд ийнхүү дүн шинжилгээ хийхдээ дараах зүйлийг анхаарна. Аргачлалын 4.5.2-т “Хуулийн төсөлд зорилгод чиглэсэн хэд хэдэн зохицуулалт, арга хэмжээг тусгасан бол арга хэмжээ, зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зорилгод хүрэх боломжийг харьцуулна” гэж заасан байна. Иймд хуулийн төслийн нэг зорилгод чиглэгдсэн хэд хэдэн зохицуулалтыг хамтад нь сонгон авч дараах үнэлгээг хийсэн болно.

Нэг. Хуулийн төслөөс сонгосон хэсэг, үнэлгээ.

Хуулийн төслөөс сонгосон хэсэг 1.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн Үзэл баримтлалд “Тамхины шинэ төрлүүд/электрон тамхи, халаадаг тамхи, зажилдаг тамхи/ болон Тамхи, тамхин бүтээгдэхүүний нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой болгож, хуульд тусгагдаагүй байсан шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний төхөөрөмжийн тодорхойлолтыг тусгаж, хуулийн зохицуулалтад оруулах” гэсэн байна. Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн энэ талаарх зохицуулалтууд болох 5.4, 13.2, дах заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

Үнэлгээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн Үзэл баримтлалд тамхины хэрэглээнд шинээр нэвтэрч байгаа электрон тамхи, халаадаг тамхи, усан хоолойгоор татдаг тамхи болон дахин сэргэж байгаа тамхийг бусад тамхины адилаар Тамхины хяналтын тухай хуулийн зохицуулалтад хамруулах” гэсэн байна. Энэ зорилгод хүрэхийн тулд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2.1-д “Тамхины хяналтын тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын бусад актаас бүрдэнэ.” гэж зааснаар ТХСК-ийн Удирдамж, зөвлөмжийг үндэслэсэн зохицуулалтыг хийх үндэслэл бүрдэнэ.

Хуулийн төслийн 3.1.1-д “Тамхин бүтээгдэхүүн”/цаашид “тамхи” гэх/ гэж татах, үнэрлэх, сорох, зажлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон никотин, бохь, химийн хортой бодис агуулсан, бүх төрлийн утаат болон утаагүй, дагалдах хэрэгсэл бүхий хэрэглээний бүтээгдэхүүнийг” гэж тодорхойлсноор уламжлалт ургамлан тамхиар хийсэн тамхинаас гадна аливаа никотин, бохь агуулсан шинэ болон шинээр гарч ирж байгаа бүх төрлийн тамхи энэхүү тодорхойлолтод хамрагдаж цаашид Тамхины хяналтын тухай хуульд туссан “тамхи” гэсэн нэрийн дорх хуулийн зохицуулалтад хамрагдах боломж бүрдэж байна.

Шинэ болон шинээр гарч ирж байгаа тамхийг хуулийн төслийн 3.1.1.1, 3.1.1.2, 3.1.1.3, 3.1.1.4, 3.1.1.5, дугаар хэсэгт тодорхойлолтыг нэмснээр хуулийн зохицуулалт ойлгомжтой болж байна. Хуулийн төслийн 9 дүгээр зүйл, 9.1 дахь заалтаас “утаат” гэсэн үгийг авснаар бүх тамхийг олон нийтийн газар татахыг бүрэн хориглох нөхцөл бүрдэнэ.

Иймд хуулийн төслийн дээрх зохицуулалтууд нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Хоёр. Хуулийн төслөөс сонгосон хэсэг, үнэлгээ.

Хуулийн төслөөс сонгосон хэсэг 2.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн Үзэл баримтлалд “Дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа байгууллагын орох хаалганы гадна талаас 10-50 метрт зайд тамхи татах цэгийг байгуулж, тамхины утаанд өртөлтийг багасгана.” гэсэн байна. Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн энэ талаарх зохицуулалтууд болох 2.1, 3.1.11, 5.1.6, 5.2.5, 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтуудыг хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсэг болгон сонгов.

Үнэлгээ.

Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслийн 2.1-д “Тамхины хяналтын тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын бусад актаас бүрдэнэ.” гэж зааснаар ТХСК-ийн Удирдамж, ТХСК-ийн шинжээчдийн зөвлөмжийг үндэслэсэн зохицуулалтыг хийх үндэслэл бүрдэнэ.

Хуулийн төслийн 3.1.11-д зааснаар “тамхи татах цэг” гэж байгууллагын орох хаалганаас 10-15 метрийн зайд байрлуулсан анхааруулах тэмдэг бүхий байршлыг” тогтоосноор аливаа байгууллагын хаалганы гадна талд тамхи татахгүй

болгож, тамхины утаа орох боломжгүй болгон ажиллагсад, үйлчлүүлэгсдийг дам тамхидалтад өртөлтөөс сэргийлэх боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн 5.1.6-д “тамхи татах цэгт тамхи татахыг зөвшөөрсөн анхааруулах тэмдэг байрлуулж, холбогдох зардлыг тухайн байгууллага өөрөө хариуцах” гэж оруулснаар байгууллагын гадна талд хаа сайгүй тамхи татах явдлыг зогсоож, тодорхой болгоно.

Хуулийн төслийн 5.2.4-д “энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м²-аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулах” гэсэн заалтын хассанаар байгууллагын тодоод орчин 100 хувь тамхигүй орчин болох нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төслийн “9.1.4.зорчигч тээврийн буудал, зочид буудал, цахим тоглоомын газар, 9.1.5.нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газар, нийтийн эзэмшлийн зогсоол, 9.1.6.аж ахуйн нэгж, байгууллагын дотоод орчин, орох хаалганаас 10-50 метр хүртэлх зайд” гэж өөрчлөлт оруулснаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан олон нийтийн газар, байгууллагын дотоод орчин 100 хувь тамхигүй орчин болгох зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэх үндэслэлтэй байна.

3.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо харилцан уялдаж байгаа эсэхийг тогтоох юм. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах аар тооцов.

“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	4.10.1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн зорилт болох тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилготой нийцэж байна.
2.	4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.
3.	4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр	Тийм	Хуулийн төсөлд оруулж байгаа тодорхойлолтууд хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна.

	томъёотой нийцэж байгаа эсэх;		
4.	4.10.4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Бусад хуулийн заалттай нийцэж байгаа.
5.	4.10.5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардал үүсгэхгүй.
6.	4.10.6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан зохицуулалт тусгасан.
7.	4.10.7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
8.	4.10.8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулалгүй тодорхой болгож, хуулийн төсөлд тамхины хяналтын давхардал, хийдэгдэл гаргахгүйгээр ажиллах, тамхи үйлдвэрлэгчдийн сөрөг нөлөөлөлд автахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, тамхины хяналтын дэвшилтэт шинэ мэдээ мэдээллийг шуурхай түгээх зорилгоор орон тооны бус салбар дундын үндэсний зохицуулах зөвлөл байгуулахаар туссан.
9.	4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Ийм төрлийн зохицуулалт тусгах шаардлагагүй.
10.	4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Ийм төрлийн зохицуулалт тусгах шаардлагагүй.
11.	4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Ийм төрлийн зохицуулалт тусгагдсан, уг зохицуулалттай нийцэж байгаа болно.

12.	4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.
13.	4.10.13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцнэ.
14.	4.10.14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуульд нийцнэ.
15.	4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Ийм төрлийн зохицуулалт тусгах шаардлагагүй.
16.	4.10.16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Хуулийн төсөлтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орно.

Дээрх судалгаанаас үзэхэд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой уялдсан, асуудал давхардаагүй байна.

Дөрөв.Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх ажиллагааг хийлээ.

Хуулийн төсөл нь тодорхой хэрэгцээ, шаардлага, судалгаа, зөвлөмж, дүгнэлт дээр үндэслэгдэн боловсруулагдсан, хуулийн төслийн эх бичвэр нь техникийн болон хэл зүйн шаардлагыг хангасан хэмжээнд бичигдсэн байна.

Хуулийн төслийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалыг чанд баримтлан, аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтийг сонгон авч, уг шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төсөлд бүхэлд нь үнэлгээ хийж гүйцэтгэв.Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Харилцан уялдаа

Хуулийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 24.5.2, 24.5.3-т заасны дагуу “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн байна.

Уг хуулийн төслөөр тавьсан зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалыг шинжилсний үндсэн дээр тогтоосон болно. Үзэл баримтлалаар тавьсан зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалт төсөлд агуулагдсан эсэх, ийм зохицуулалт агуулсан боловч тэдгээр нь зорилгыг хангах боломжтой эсэхийг үнэлэв.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзвэл хуулийн төслийг боловсруулахдаа тамхины эрэлтийг бууруулах, тамхины дам тамхидалтаас хүн амыг хамгаалах, тамхины нийлүүлэлтийг багасгах импортлох тусгай зөвшөөрөл олгох журам батлах, тухайн жилд импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээг тогтоох зорилго тавьсан байх ба уг зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалт бүхий 13 зүйлтэй, эдгээр нь хоорондоо харилцан уялдаа бүхий, зорилгод хүрэх бүрэн боломжтой байдлаар боловсруулагдсан гэж дүгнэгдсэн болно.

“Зорилгодоо хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой гэж дүгнэж байна.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бусад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцсэн, хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйлүүд нь хоорондоо уялдсан байна.

Зөвлөмж:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгагдсан дараах зохицуулалтуудыг нэмэлт, өөрчлөлт байдлаар хуульд тусгахыг зөвлөж байна. Үүнд:

- Тамхи, тамхин бүтээгдэхүүний тухай ойлголтыг өргөжүүлж, тодорхой болгон хуульд тусгагдаагүй байсан шинэ болон шинээр гарч ирж байгаа тамхины төрлүүд/халаадаг тамхи, никотин бүхий электрон тамхи, никотингүй электрон дамжуулах систем бүхий тамхи/ тамхин бүтээгдэхүүн гэсэн тодорхойлолтод тусгаж томъёолох,
- Тамхины шинэ төрлүүд, төхөөрөмжийг бусад тамхины адилаар хуулийн зохицуулалтад хамруулах эсвэл импорт, худалдаа, үйлдвэрлэлийг хориглох,
- Байгууллагын дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа байгууллагын орох хаалганы гадна талаас 10-15 метрт зайд тамхи татах цэгийг байгуулж тамхины утаанд өртөлтийг багасгах,
- Худалдааны байгууллагад тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж тамхи татах сэдэл төрөх нөлөөллийг бууруулах,
- Тамхины хайрцагны ар болон нүүрэн талын талбайн хэсгийн эрүүл мэндийн зурагт анхааруулгын хэмжээг 70%, бичвэр анхааруулгыг тамхины таглааны нүүрэн талын хэсэгт байрлуулах эсвэл тамхины хайрцаг, сав баглаа боодлын өнгийг бор өнгөтэй болгон тамхи татах сэдлийг төрүүлэх үйлдлийг багасгах,
- Худалдааны байгууллагад тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж тамхи татах донг сэдрээх нөлөөллийг бууруулах,
- Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах, үнэгүй тараах, татварын хөнгөлөлт үзүүлэхийг хориглох,

- Нийгмийн сүлжээ, клип, шторк, импортын болон дотоодын кино, нэвтрүүлэгт тамхи хэрэглэсэн үйлдлийг үзэгчдэд харагдахааргүй болгон бүдэгрүүлж байх заалтыг хуулинд оруулах, хариуцлага ногдуулах,
- Тамхи татах донг сэдрээх байдлыг бууруулах зорилгоор бренд өргөтгөх зорилго бүхий бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох,
- Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг зохицуулах салбар хоорондын үндэсний зохицуулах механизмыг албан ёсоор байгуулах нөхцлийг хуулинд тусгах,
- Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг илрүүлэх хяналтыг сайжруулах эрхзүйн орчин бүрдүүлэх,
- ТХСК-ийн 14 дүгээр Удирдамжийн хэрэгжилтийг хангаж, тамхины хамаарлын эмчилгээний эм, бэлдмэлийн хүртээмж, хангамжийг сайжруулах, хууль бус эм бэлдмэлийг хориглох,
- Тамхинд ногдуулах татаварын хэмжээг ТХСК-ийн зөвлөмжид хэмжээнд хүргэх бодлогыг төрийн бодлогод тусгах
- Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулдаг болох,
- Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй бол тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох эрх зүйн боломж бүрдэж, тамхины импортын хэмжээ буурахад нөлөөлнө.
- Дэлхий нийтэд тамхины ургамал тариалалтыг багасгаж ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах бодлогод шилжих зөвлөмжийг өгч байгаа тул Тамхины хяналтын тухай хуульд тамхины ургамал тариалахыг хориглох зэрэг болно.

-oOo-